



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2016 оны 1 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот


Ажлын хэсэг байгуулах тухай

1. Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, зөвшөөрөлтэй холбогдох үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв” байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Дарга	-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Дэд дарга	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга
Гишүүд:	-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга; -Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга; -Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга; -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга; -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын хэвлэлийн төлөөлөгч; -Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын захирал.

Нарийн бичгийн -Засгийн газрын референт.
дарга

2. “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийг байгуулах төлөвлөгөө боловсруулж, үйлчилгээний төрөл, хэлбэр, шаардагдах зардлын тооцоо, хэрэгжүүлэх бусад арга хэмжээний талаарх саналыг 2016 оны 1 дүгээр сард багтаан Ерөнхий сайдад танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ